



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/В 87

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 32.3 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын 2.2.3, 2.4.1.8 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөрийн 3.1.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үр хөндөлтийг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээний “Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ” MNS 5488:2019 Монгол Улсын стандартын дагуу орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газрын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Үр хөндөлтийн хор уршиг, ялангуяа аюултай үр хөндөлтөөс сэргийлэх талаар олон нийтэд сурталчлах ажлыг эрчимтэй зохион байгуулан, гарын авлага, зурагт хуудас, видео боловсруулан мэдээлэл сургалт сурталчилгааны арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /Д.Нарантуяа/, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, Монгол улсын “Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ” MNS 5488:2019 стандарт, энэхүү журмыг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний “Эмчлэх, сувилах, эм барих” зөвшөөрлийг хүчингүй болгохыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга нарт тус тус даалгасугай.
5. Уг журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цахим зөвлөгөө, үр хөндөлтийн тусламж үйлчилгээний аюулгүй, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/, ЭМЯ-ны дэргэдэх Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл /Д.Мөнхцэцэг/ нарт даалгасугай.

081474

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Бямбадорж/-д даалгасугай.

7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 148 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 08 сарын 15 өдрийн  
А/Б 87 дугаар тушаалын хавсралт

## ҮР ХӨНДӨЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалт, “Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ” MNS 5488:2019 Монгол Улсын стандартыг хэрэгжүүлэн, үр хөндөлттэй холбоотой асуудлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1. Үр хөндөлтийг жирэмсний хугацаагаар нь эрт ба хожуу гэж ангилна.

1.1. “Эрт үеийн үр хөндөлт” гэж жирэмсний эхний 12<sup>+6</sup> долоо хоногийн дотор үр хөврөлийг умайгаас эмнэлгийн аргаар гаргахыг хэлнэ.

1.2. “Хожуу үеийн үр хөндөлт” гэж жирэмсний 13 долоо хоногоос 21<sup>+6</sup> долоо хоногийн дотор жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслахыг хэлнэ.

2. Эрт үеийн үр хөндөлтийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн журам, зааврын шаардлагыг хангасан, гарч болох хүндрэлээс сэргийлэх, эмчлэх бэлтгэлийг бүрэн хангасан, хүндрэлээс сэргийлэх, хүндрэл гарсан тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх бэлтгэл бүрэн хангагдсан, 24 цагаар үйлчилгээ үзүүлдэг, “Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах” тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг, клиник, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн сум дундын эмнэлэгт, эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээтэй эмч үр хөндөхийг зөвшөөрнө.

3. Эрт үеийн үр хөндөлтийг эмэгтэйн өөрийнх нь хүсэлтээр төлбөртэйгээр, эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр төлбөргүйгээр холбогдох шинжилгээг бүрдүүлж, зөвхөн эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч гүйцэтгэнэ.

4. Хожуу үеийн үр хөндөлтийг мэргэжлийн эмч нарын дүгнэлт, зөвлөгөөний шийдвэрээр дор дурьдсан заалтаар зөвхөн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Амаржих газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээтэй эмч үр хөндөх ажилбарыг хийнэ.

4.1. Тухайн жирэмслэлт нь эхийн амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон;

4.2. Ургийн эмгэг нь амьдралд үл нийцэх гажиг болох нь тогтоогдсон;

4.3. 18 хүртэлх насны охид өөрөө хүсвэл эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр;

4.4. 40-өөс дээш насны эмэгтэй өөрөө хүсвэл;

4.5. Цусан төрөл ойртсон нь нотлогдсон;

4.6. Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн;

5. Дээр дурьдсан заалтуудаас бусад тохиолдолд жирэмснийг хожуу хугацаанд таслахыг хориглоно.

6. Дараахь тохиолдолд үр хөндөхийг түр хойшлуулж, холбогдох эмчилгээг хийсний дараа үр хөндөх ажилбарыг гүйцэтгэнэ. Үүнд:

6.1. Эрхтэн тогтолцооны цочмог үрэвсэл болон архаг үрэвсэлт өвчний сэдэрэлттэй,

6.2. Бөөр шээсний зам болон бэлэг эрхтний хурц үрэвсэл оношлогдсон бол

7. Үр хөндөх ажилбар хийсэн эмч тухайн ажилбарын талаар “Үр хөндөлт”-ийн түүхэнд тэмдэглэж, үр хөндөлтийн бүртгэлийн маяганд бүртгэнэ.

8. Эрт үеийн үр хөндөлт хийхийн өмнө эмэгтэйд үр хөндөлтийн талаар таниулж, сонгосон аргаар үр хөндүүлэх зөвшөөрлийг бичгээр авч, “Үр хөндөлт”-ийн түүхэнд хавсаргана.

9. Хожуу үед үр хөндөхөд дараахь баримт бичгийг бүрдүүлж, “Үр хөндөлт”-ийн түүхэнд хавсаргана. Үүнд:

9.1. Эмч нарын зөвлөгөөний шийдвэр,

9.2. Үр хөндүүлэх эмэгтэйн өөрийнх нь, 18 хүртэлх насны охидын эцэг, эх, асран хамгаалагчийн, иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, зөвшөөрлийг бичгээр авсан байна,

9.3. Хэрвээ бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн тохиолдолд хууль, хяналтын байгууллагын тодорхойлолт,

9.4. Цусан төрөл ойртсон нь нотлогдсон хууль, хяналтын байгууллагын тодорхойлолт.

10. Үр хөндөлтийн дараа гарч болох хүндрэл, жирэмслэхээс сэргийлэх үр дүнтэй аргын талаар зөвлөгөөг үйлчлүүлэгчид өгч, энэ тухай “Үр хөндөлт”-ийн түүхэнд тэмдэглэнэ.

11. Эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан эмч үр хөндөлтийн тухай тайланг ЭМС-ын 2013 оны 450 тоот тушаалын ЭМТ-201.12 батлагдсан маягтын дагуу нэгтгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн мэдээллийн албанд мэдээллэнэ.